

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТУХАЙ

УИХ-ын дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг Та бид ихээхэн онцлог, эгзэгтэй цаг үед хэлэлцэж байна. Европын өрийн хямрал, Хятадын эдийн засгийн удаашрал, АНУ-ын төсвийн хямрал, Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл муудах, гадаадын шууд хөрөнгө оруулалт агших үзэгдэл үргэлжилж, манай эдийн засагт сөргөөр нөлөөлсөн хэвээр байна.

Энэхүү таагүй орчинд Монголбанкны бодлого нь зөвхөн үнийн тогтвортой байдлыг хангах хүрээгээр хязгаарлагдалгүй, эдийн засгийн хүндрэлийг саармагжуулах, бүтцийн шинэчлэл, бодит секторын идэвхжилийг дэмжих, өрхийн болон үндэсний хуримтлал, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэж ирлээ.

Монголбанк дээрх бодлогын хүрээнд 2012 оны сүүлийн хагасаас мөнгөний нийлүүлэлтийг тодорхой үе шаттайгаар, хувийн хэвшлээр дамжуулан хийхдээ М2-ын өсөлтийг 20 хувиас хэтрүүлээгүй болно. Энэхүү нийлүүлэлтийг хийхдээ:

Нэгд, Монголбанк нийлүүлэлтийн гаралтай инфляцийг хязгаарлах зорилгоор “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд 623 тэрбум төгрөгийг хямд, богино хугацаатай эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр хэлбэрээр эдийн засагт нийлүүлээ.

Хоёрт, Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, зээлийн хүүний өсөлтийг зогсоох, 2012 оны сүүлээс үүсч болзошгүй байсан зээлийн тасалдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 900 тэрбум төгрөгийн богино хугацаат хадгаламжийг банкуудад байршууллаа.

Гуравт, дээрх хоёр арга хэмжээний үр дүнд инфляци буурч, санхүүгийн салбар тогтворжихын хэрээр бодит секторыг дэмжих зорилгоор Монголбанкны бодлогын хүүг 3 удаа, нийт 2.75 нэгж хувиар бууруулсны зэрэгцээ 430 тэрбум төгрөгийг 18 сарын хугацаагаар эдийн засагт нийлүүлээ.

Эдгээр арга хэмжээ нь **үндэсний болон өрхийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн** орон сууцны ипотекийн санхүүжилтийн шинэ тогтолцоог бий болгох боломжийг бүрдүүлсэн. Энэ зорилтын хүрээнд Монголбанк өнөөдрийн байдлаар орон сууцны ипотекаар баталгаажсан үнэт цаасанд хөрвөх нөхцөлтэй 1.3 их наяд төгрөгийг банкуудад байршуулсан юм.

Дээрх арга хэмжээний үр дүнд Монголын эдийн засагт 2013 онд тулгарч байсан хүндрэлүүд саармагжиж, оны эхний хагаст нийт М2 мөнгө 13.5 хувиар, ДНБ 11.3 хувиар өсч, инфляци 8.8 хувь болж буурсан үзүүлэлттэй гарлаа. Төгрөгийн зээлийн хүү жилийн 18.3 хувиас 2013 оны 8 дугаар сарын байдлаар 16 хувь болж 2.3 нэгж хувиар буурлаа.

2013 оны эхний 7 сард 7.7 хувиар суларч байсан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 8 дугаар сараас эхлэн огцом хэлбэлзэж, өнөөдрийн байдлаар оны эхнээс 21.2 хувиар суларсан үзүүлэлттэй байна.

Нэрлэсэн ханш ийнхүү суларсан нь гадаад худалдааны нөхцөл муудсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс буурсан таагүй орчин үргэлжилсээр байгаагийн илрэл төдийгүй 7 дугаар сарын сүүлчээр валютын захад үүссэн огцом цочрол, сөрөг хүлээлтийн үр дагавар гэж үзэж байна.

Монгол шиг гадаад худалдааны эргэлт нь ДНБ-ээс давсан эдийн засгийн хувьд валютын ханшийн хэт огцом өөрчлөлт нь эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй. Нөгөө талаас ханш сулрах нь богино, дунд хугацаанд манай эдийн засгийн өрсөлдөх чадвар болон экспортын боломжийг алдагдуулахгүй байх, гадаад валютын улсын нөөцийг хамгаалах, гадаад худалдаа, урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах, улмаар эдийн засагт бүтцийн шинжтэй томоохон шинэчлэл хийх урьдач нөхцөлийг хангахад чухал үүрэгтэй гэж бид үзэж байна.

Иймд Монголбанк ханшийн өөрчлөлтийн хандлагыг өөрчлөлгүйгээр, зөвхөн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор валютын захад оролцож, гадаад валютын улсын нөөцийг хамгаалж ирлээ.

Монгол Улсын гадаад валютын нөөц 2013 оны 9 дүгээр сарын байдлаар 2.7 тэрбум ам.доллар байгаа нь нийт валютын төлбөртэй импортын 5.4 сарын хэрэгцээг хангах хэмжээнд буюу олон улсын жишгээс өндөр түвшинд байна.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Монголбанк макро тогтвортой байдлыг хангах, иргэдийн бодит орлогыг хамгаалах үүднээс 2014 онд инфляцийг 8 хувь, улмаар 2015-2016 онуудад 7 хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгах зорилтыг дэвшүүлж байна.

Монголбанк 2014 онд улсын төсөв тогтвортой, гадаад валютын урсгал харьцангуй сайжирна гэсэн хүлээлттэй байна. Энэхүү хүлээлтэд үндэслэн дотоодын үйлдвэрлэлийг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжиж, эдийн засгийн өрсөлдөх чадвар, дархлааг сайжруулсны үр дүнд суурь инфляцийг бууруулах чиглэлээр ажиллах болно.

Монголбанк зээлийн хүүг цаашид бууруулах, зээлийн хүртээмжийг сайжруулахад онцгой анхаарах болно.

Инфляцид үлэмж нөлөөтэй нийлүүлэлтийн хүчин зүйлсийн дарамтыг бууруулахын тулд хэрэгжүүлж байгаа “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийн үр нөлөөг дээшлүүлэх, бараа бүтээгдэхүүний хангамжийн зах зээлийн зарчимд суурилсан, урт хугацаанд үр ашигтай ажиллах механизмыг бүрдүүлэхэд Засгийн газар ихээхэн идэвхи, санаачлагатай ажиллана гэж найдаж байна.

Санхүүгийн үүсмэл хэрэгслээр ханшийн эрсдэлийг бууруулан үнийг тогтворжуулах бүрэн боломжтойг “Шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр”-ийн үр дүн харуулж байна. Иймд суурь инфляци, импортлогдож буй инфляцийн нөлөөллийг багасгах зорилгоор Монголбанкнаас 2014 онд төгрөгийн орлоготой этгээдийн валютын ханшийн эрсдэлийг бууруулах санхүүгийн бүтээгдэхүүнийг илүү боловсронгуй болгож, зах зээл дэх хэрэглээг нь нэмэгдүүлнэ. Ингэснээр валютын ханшийн өөрчлөлтийн инфляцид үзүүлэх нөлөөллийг эрс сулруулна гэж үзэж байна.

Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог цаашид ч үргэлжлүүлнэ. Уг тогтолцооны хүрээнд үндэсний болон өрхийн хуримтлал нэмэгдэж, үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл хөгжин, Нийгмийн даатгалын сан хөрөнгөжиж, хөдөлмөрийн зах зээл, татвар, шимтгэлийн орчин илүү ил тод, тунгалаг болно гэж үзэж байна.

Эрхэм гишүүд ээ,

Макро эдийн засгийн бодлого нь зөвхөн санхүүгийн эрүүл, тогтвортой системээр дамжин үр дүнтэй хэрэгжих боломжтой тул Монголбанк санхүүгийн салбарын тогтвортой байдалд онцгой анхаарч ажиллаж ирлээ. 2013 оноос эхлэн манай бүх банк зохистой харьцааны болон өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүдээ бүрэн хангаж байна.

Банкны эх үүсвэрт харилцах, хадгаламж давамгайлж, хугацаа нь богино байгаа нь урт хугацаатай хөрөнгө оруулах бололцоог бууруулсан хэвээр байна. Иймд хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, төлбөрийн чадварыг бэхжүүлэхэд Монголбанк онцгойлон анхаарна.

Зээлийн барьцаа хөрөнгийн өмчлөх эрхийг банкны мэдэлд шилжүүлэхэд их хэмжээний зардал, хугацаа зарцуулдаг түгээмэл зөрчлийг арилгах, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг оновчтой хангуулах зорилгоор 7 хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг УИХ-д өргөн барихаар төлөвлөж байна. Үүний үр дүнд зээлийн эрсдэл буурч, иргэд, аж ахуйн нэгжид олгох зээлийн хүү буурах эерэг нөхцөл бүрдэх юм.

Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өсөлт, ил тод байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор төлбөр тооцооны системээр дамжин хийгдэж буй банк хоорондын гүйлгээний тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, 2013 оны байдлаар банк хооронд хийгдсэн гүйлгээний дүн 34 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өсчээ. Монголбанк төлбөрийн системийг цаашид улам боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын төлбөрийн системийг хөгжүүлэх төслийг Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкттай хамтран хэрэгжүүлнэ.

Санхүү, банкны салбарын харилцагч, хадгаламж эзэмшигч нарын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үүднээс “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг холбогдох байгууллагатай хамтран 2014 онд боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох замаар макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах ажлыг үргэлжлүүлнэ.

2012 оны 10 дугаар сард олон улсын жишгийн дагуу анх удаа Мөнгөний бодлогын зөвлөлийг шинээр байгуулан ажиллуулж ирлээ. Мөнгөний бодлогын зөвлөл нь бодлогын шийдвэрийг мэргэжлийн түвшинд, олон нийтэд нээлттэй, ил тод гаргадаг болсон. Цаашид 2014 онд мөнгөний бодлогын зөвлөлийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх замаар мөнгөний бодлогын шийдвэр гаргалтыг илүү боловсронгуй болгож, Төв банкны ил тод, нээлттэй байдлыг ахиулах болно.

Монголбанк 2013 оны төрийн мөнгөний бодлогыг эдийн засагт үүссэн хүндрэлийг саармагжуулах, макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглүүлэн, зохих үр дүнд хүрээд байна. Бид хүрсэн ололт, амжилтаа бататгаж, бодит секторыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжих замаар эдийн засгийн дархлааг сайжруулахад 2014 оны төрийн мөнгөний бодлогыг чиглүүлэх болно.

Эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэж, баталж өгөхийг хүсье.